

蒙古语阅读教程

(三年级第一册)

齐 心 编

中国人民解放军外国语学院

2005.05

使用说明

本教程供蒙古语专业本科三年级上学期使用。

教材内容按不同专题共分六个单元，每单元三课，全册共十六课。六个单元的专题分别是蒙古文化、蒙古文学、蒙古法律、蒙古外交、蒙古军事和蒙古经济。

每课内容由课文、注释和练习组成，课文后附该课文字数统计。注释采用脚注形式。练习主要是针对课文内容的讨论题和简述题，并有少量翻译题。

实际教学时，原则上按照教材各单元顺序使用，教材的一课为一周的阅读教学量。在具体安排教学活动时，教员可根据教学实际情况安排教材顺序和删选教材内容。

为弥补学员阅读材料之不足，教材最后附有二篇文章供学员课外自主选择阅读。

编者

2005年5月

ГАРЧИГ

I бүлэг : СОЁЛ

- | | |
|--------------------------|----|
| 1. Цээрлэх ёсон | 1 |
| 2. Монголын шашин шүтлэг | 11 |
| 3. Монгол бичиг үсэг | 16 |

II бүлэг : УРАН ЗОХИОЛ

- | | |
|---------------------|----|
| 4. Буурал ижий минь | 22 |
| 5. Жинхэнэ сонгууль | 35 |
| 6. Үнэгэн дээл | 42 |

III бүлэг : ХУУЛЬ

- | | |
|---------------------------------|----|
| 7. Монгол улсын үндсэн хууль(1) | 55 |
| 8. Монгол улсын үндсэн хууль(2) | 65 |
| 9. Монгол улсын үндсэн хууль(3) | 76 |

IV бүлэг : ГАДААД ХАРИЛЦАА

- | | |
|--|----|
| 10. Хятад, Монгол хоёр үүрдийн сайн хөрш, сайн түнш болох
нь дамжигүй | 85 |
| 11. Монгол, Хятадын хамтарсан мэдэгдэл | 93 |
| 12. Монгол-Хятадын харилцаа ба гурвалжны доторх
Монгол-Америкийн харилцаа | 99 |

V бүлэг : ЦЭРГИЙН ХЭРЭГ

- | | |
|--|-----|
| 13. Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс | 109 |
| 14. Зэвсэгт Хүчний өөрчлөлт, шинэчлэлт, үр дүн | 119 |
| 15. Хамтарсан цэргийн сургууль: | 125 |
| а. АНУ-ын Тэнгисийн явган цэрэг, Монгол улсын Зэвсэгт
хүчинтэй хамтарсан “Хааны эрэлд” цэргийн сургууль | |
| б. Цасан шуурга ч “ Хааны эрэлд” саад болсонгүй | |

VI бүлэг : ЭДИЙН ЗАСАГ

16. Монгол улсын эдийн засаг, нийгмийн байдал	129
17. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиас	136
18.а.Макро эдийн засгийн өсөлт, Монголын хөрөнгө оруулалтын нууц	142
б. Монгол Улсын оёдлын бүтээгдэхүүний экспортын төлөв	145
хавсралт1: Өөдрөг явах 25 зарчим	148
хавсралт2: Газар эх	150

1-р хичээл

МОНГОЛ АРДЫН УЛАМЖЛАЛТ ЦЭЭРЛЭХ ЁСОН^①

Олон зууны туршид монголчуудын баримтлан дагаж ирсэн цээрлэх ёсон^② нь нийгэм, хүний амьдралын олон талыг хамарсан^③ монгол хүний сэтгэл, хүн чанар, ахуй амьдралын өвөрмөц онцлогийг тусгасан^④ байдаг.

1. Зочныг угтах, үдэхтэй холбогдсон цээрлэх ёсон

- Зочин ирэхэд байцаах^⑤ маягтайгаар гэр дотроосоо шалгаах, уцаарлах, зандрохыг^⑥ цээрлэнэ.

- Зочин ирэхэд шагайж харах, нөмгөн^⑦ гарах, үс гэзгээ сэгсийлгэж гарахыг цээрлэнэ.

- Зочны өөдөөс үнс^⑧, хог, тогоо авч гарах, тогоо хөөлөх^⑨, угаадас асгахыг цээрлэдэг.

- Зочин ирэхэд гэрийн хүмүүс хоорондоо хэрэлдэж маргах, хүүхдээ загнах зодохыг тэвчих^⑩ ёстой.

- Зочныг ирэхэд ба байхад нь бүдүүлэг буюу бэлэггүй үг, хараал хэлэхийг цээрлэдэг.

- Айлд ирж байгаа зочин хүн тэр айлын зэл, шилбүүр, уурганы^⑪ дээгүүр алхдаггүй.

- Буу, зэвсэг, ташуур барьж ордоггүйгээс гадна хутгаа бүснээсээ авч доош унжуулж^⑫ ордэг.

- Ирсэн зочин айлын гадаа ирээд мэндэлдэггүй, гэрт орсон хойно

① 本课文选自《монгол ардын уламжлалт ёс, зан үйлийн дээж》一书，作者 Ичинхорлаагийн Цоодол。

② 禁忌, 禁忌习俗。

③ 包含, 包括。

④ 反映, 反射, 反照。

⑤ 侦讯, 侦察; 审讯; 调查, 检查。

⑥ 反复地问、不耐烦和厉声喝斥。

⑦ 披着的, 穿袍不系带子的。

⑧ 灰, 灰烬; 灰色。

⑨ 清除烟灰, 清除锅底灰。

⑩ 戒除, 禁忌; 放弃, 摒弃; 节制, 抑制, 克制; 忍住, 忍耐。

⑪ 拴牲畜的长牵绳、长杆鞭子和套马杆。

⑫ 使下垂, 使悬挂。

мэндлэх ёсон бий.

- Ирсэн зочин тэр айлын эзэн, эзэгтэйн заасан газраас өөр газар суух, эмэгтэй хүний ор, лам, эрдэмтэн, номын хүний суудал дээр суухыг цээрлэдэг ёстой.

- Ахмад настай, лам, номын хүний гэрт энгэр заам задгай^① ордоггүй.

- Зочин ирэхэд угтаж гарч бие засах мөн ирсэн зочин буунгуут бие засахыг цээрлэдэг.

2. Идэх, уух, зочлолтой холбоотой цээрлэх ёсон

- Цайг буруу барьж уух, цай, айрагны аягыг долоодоггүй. Харин тараг, хоолны аягыг долоодог.

- Сүүж, богтос, богино хавирга, далны мөгөөрс, өвчүүний бүдэрхийг^② монголчууд хүндэтгэлийн бус мах гэж үздэг тул зочинд чанаж өгдөггүй.

- Ясыг хутгаар хусдаггүй^③. Учир нь монголчууд атаа хорслыг^④ “Ясаа хусалцах” гэж нэрлэдэг болохоор яс хусахыг цээрлэдэг.

- Сэмжийг^⑤ урж иддэггүй. Учир нь өлөн ховдогийн^⑥ шинж гэж үздэг.

- Монголчууд зочин ирэхэд нүдий нь авсан толгой, нүхий нь ухсан сүүж, нүнжигий^⑦ нь авсан дал гурвыг ил харуулахыг цээрлэдэг. Эдгээр гурвыг гэрт хонуулахыг бүр ч цээрлэдэг бана.

- Галд сүү өргөхийг цээрлэдэг. Галд сүү өргөвөл мал ширгэнэ^⑧. Нүд сохорно гэж үздэг.

- Монгол хүн сүүн дээр ус хийдэггүй, харин усан дээр сүү хийдэг нь бэлэгдлийн шинжтэй юм.

- Олуулаа, айлд зочлоход хамгийн ахмад хүн идээ зоогт гар ам хүрээгүй байхад бусад нь хүрэхийг цээрлэдэг.

- Зочин хүн ховдоглон их идэж уухыг цээрлэдэг. Монголчууд эртнээс “Юу байгаагаараа дайлах нь хүний ёс, юу ч үгүй дуусгах нь

① 敞着衣怀或领口。

② 肋骨、桡骨、短肋骨、肩胛软骨、胸骨柄。

③ Хусах 刮，铲；刮平。

④ 嫉恨，仇恨。

⑤ 网膜。

⑥ 贪婪的。

⑦ 油脂，肥腻；光泽，光润。

⑧ 蒸发，晒干，干涸；（乳畜）回奶，奶变少。

нохойн ёс” гэж хошигнож^① ирсэн нь мэргэн үг ажээ.

- Зочныг хоол идэж байхад нь яриа үүсгэдэггүй. Хүнд хутга сэрээг өгөхдөө ишний нь талыг түрүүлүүлж өгдөг.

- Монгол хүн махыг хөндлөн огтлож идэхийг цээрлэдэг.

- Зочинд цай, айраг, архи аягалахдаа аяганд нар зөв эргүүлж хийх ба аягалж байхдаа аяга руугаа амьсгалаа эгц хандуулах ярьж шүлсээ^② үсэргэхийг цээрлэж болгоомжилдог ёстой.

3. Хувцас хэрэглэлтэй холбогдсон ёсон

- Монгол хүн дээлийнхээ захыг өөрийнхөө хийморь^③ гэж үздэг учраас захан дээр гишгэх, уруу харуулж тавихыг цээрлэдэг. Хуучирч хэрэггүй болсон дээл, цамцаа хаяхдаа захы нь авч хаядаг ёстой.

- Бүсийг ба малгайг эрх чөлөөний бэлэг тэмдэг гэж үздэг учир бүс малгайн дээгүүр алхахыг цээрлэж ямагт дээр тавьдаг.

- Дээлийн ханцуйг хүч, санааны бэлэгдэл гэж үзэх тул дээлээ тайлж тавихдаа ханцуйгаа бүсээрээ уяж орхидог. Ханцуйг сул хоосон оршихыг цээрлэнэ.

- Дээлийн ханцуйг дотогш нугалан шамлахыг^④ цээрлэн энгэр заамаа задгайлж айлд орох, хүнтэй уулзахыг цээрлэдэг. Ингэсэн хүн тааралдвал “хэнтэй зодолдох гэв?” гэж асуугаад өөр үг солилгүй салж явдаг ёстой.

- Эх, эцэг, ахмад хүний дэргэд ууж^⑤ тайлах дотоод энгэр ярахыг^⑥ цээрлэдэг ёстой.

- Ахмад буюу албаны хүний дэргэд хормой шуух^⑦, дээл сугалдаргалахыг^⑧ цээрлэдэг.

- Бүсээ бусдын эхнэрээр бүслүүлэх эсвэл нар буруу ороохыг^⑨ цээрлэдэг.

- Давхар малгай өмсдөггүй. Хоёр эхнэр авдаг гэж үздэг.

① 说笑话，开玩笑；讽刺，讥讽。

② 涎水，唾液，口水。

③ 灵魂；生气，朝气；运气，幸运。

④ 撙起，挽起，卷起，卷上（袖子等）。

⑤ 坎肩，背心。

⑥ 分开，打开，揭开，敞开。

⑦ 掀起前襟。

⑧ 单臂袒露（穿衣时一只胳膊抽出衣袖）。

⑨ 包缠，缠绕，捆；纠缠。

- Гутлын түрий^① эргүүлэхийг муу ёс гэж үздэг учир нь хонгор азарга^② хэмээх эрүү шүүлтэнд^③ орох хүний гутлын түрийг эргүүлдэг байна.

- Гутлын улыг^④ бурхан, шүтээн өөд харуулж тавьдаггүй ёстой.

- Малгайг хүнд бэлэглэдэггүйн учир гэвэл уруугаа харсан сав тул буян хишиг асгана гэж үздэг байна.

- Гэрт гадаа хаана ч эмээлийн бүүргийг^⑤ уруу буруу харуулж тавьдаггүй.

- Хутга мэсээр газар бүлдэггүй^⑥, амандаа зуудаггүй.

- Хайчны амыг хоосон ангалзуулдэггүй^⑦, чонын ам ширүүсч мал хорогдоно гэж үздэг.

- Дээлийн зах, гутлын түрийг гал уруу харуулж тавьдаггүй.

- Түлхүүр сэгсэрч, шидэхийг хогшил^⑧ цайна, сампин^⑨ хоосон эргүүлэхийг өр^⑩ алдана гэж цээрлэнэ.

4. Хүүхдээ хүмүүжүүлэхтэй холбогдсон цээрлэж ёсон

- Хэтэрхий амтатнаар^⑪ хангалуун байлгавал хэнэггүй^⑫, голомхой^⑬ болно гэж цээрлэнэ.

- Гашууныг амсуулж дасгавал архичин болно гэж цээрлэнэ.

- Хэтэрхий өнгө үзэмжинд дасган сургавал ганган хээнцрээс^⑭ өөр юмгүй болно гэж цээрлэнэ.

- Хар багаас нь тансаг^⑮ эд юманд умбуулбаас^⑯ эдийн шуналтай^⑰, бэлэнчлэх^⑱ бодолтой болно гэж цээрлэнэ.

① 靴腰, 靴筒; 袜筒。

② 公马, 牡马; 牡的, 公的。

③ 刑具; 拷问, 刑讯。

④ 脚掌; 靴底, 鞋底; 底部, 底座。

⑤ 鞍鞅。

⑥ бүлэх 刺, 扎。

⑦ ангалзах 张开, 一张一合; 张口结舌。

⑧ 家具; 财产; 木器。

⑨ 算盘。

⑩ 债, 债务。

⑪ амттан 美味的食品, 甜食。

⑫ 胸怀宽广的; 无忧无虑的; 无动于衷的, 麻木不仁的, 若无其事的。

⑬ 嫌弃的, 嫌恶的; 鄙视的, 看不起的。

⑭ 好穿戴的, 时髦的, 风流妖艳的。

⑮ 欢乐; 美妙的; 娇爱的, 溺爱的; 高级的。

⑯ умбах 游泳, 潜水; 沉溺于……, 迷醉于……; 滥用, 挥霍。

⑰ 贪婪的, 贪得无厌的。

⑱ 坐享其成, 贪图现成。

- Нойронд автуулахыг цээрлэж,эрт босгож сургадаг.
- Уурлах, уцаарлахыг цээрлэж уужуу тайван сургадаг.
- Залхуу хойргыг^① цээрлэж, ажилсаг, зүтгэлийг сургана.
- Заваан замбараагүйг^② цээрлэн эмх цэгцийг эрхэмлэнэ.
- Хов зөөх^③, илүү үг ярихыг цээрлэн, үнэн цөөн үгтэй сургадаг.
- Худалч, хуурмагийг цээрлэж, үнэнч, ариуныг эрхэмлэнэ.
- Хувиа хичээхийг цээрлэн, тусархаг, нөхөрсөгийг сургана.
- Их идэхийг цээрлэн, цагтай хэмжээтэй идүүлж сургадаг.
- Ажиггүй^④, алгуурыг цээрлэнэ, ажигч гярхайд^⑤ сургана.
- Ашигч шунахайг цээрлэн, амарлингуй өглөгч^⑥ сургана.
- Атаа жөтөөг^⑦ цээрлэн ариун бодь^⑧ сэтгэлтэй сургана.
- Аймхай хулчгарыг^⑨ цээрлэн зоримог эрмэг^⑩ сургана.
- Аргацаах^⑪, нүд хуурахыг^⑫ цээрлэн алсын хараатай, туйлбартай^⑬ сургана.
- Хагуу, харигийг^⑭ цээрлэн, хайрлах энэрэхэд сургана.
- Үрэлгэн^⑮ гамгүйг цээрлэн,өсгөх,хямгадахад^⑯ сургана.

5.Байгаль хамгаалахтай холбогдсон цээрлэх ёсон

- Онцгой өөр өнгөтэй чоно, тарвага^⑰, үнэг, өөр эвэртэй зээр^⑱ гөрөөс зэргийг агнахыг цээрлэдэг.
- Ан амьтдыг хээлтэй^⑲ байх буюу үр төл нь нялх байх үед агнахыг цээрлэдэг.

① 懒惰的, 偷懶的.

② 混亂的, 一團糟的, 亂七八糟的.

③ 造謠誣蔑, 散布謠言, 傳閑話, 挑撥離間, 搬弄是非.

④ 缺乏注意的, 滿不在乎的, 輕視的, 掉以輕心的.

⑤ Гярхай 眼光敏銳的, 眼尖的; 辨認力強的.

⑥ 慷慨的, 大方的, 毫不吝嗇的, 好施舍的.

⑦ 嫉妒, 醋意.

⑧ 菩提; 善良, 慈善.

⑨ 胆怯的, 胆小的, 懼怕的.

⑩ 勇敢的, 剛毅的, 無畏的.

⑪ 寻找方法, 想办法; 湊合, 將就; 哄住.

⑫ 騙过眼睛; 蒙蔽, 蒙混, 敷衍, 搪塞.

⑬ 完全的, 徹底的, 有始有終的.

⑭ 水流回旋处, 漩涡; 反向进行的.

⑮ 浪费的, 揮霍的.

⑯ хямгадах (对物品) 变得爱惜, 变得爱护, 变得珍惜, 变得节俭.

⑰ 旱獭, (草原上的) 土拨鼠.

⑱ 黄羊; 蒙古原羚.

⑲ (动物) 怀胎的, 妊娠的, 怀孕的.

- Ховордсон ан амьтад сүргийн манлайг^① агнах, орооны үед^② нь агнахыг цээрлэдэг.

- Алсаас яваа гүйгүүл^③ амьтан, өөр өөрийн отог омгийн^④ шүтээн амьтныг алахыг цээрлэнэ.

- Ангийн махыг хөөдөх^⑤, бусдаас харамлахыг^⑥ цээрлэдэг.

- Булаг шандын эхийг ухах хөндөхийг^⑦, хамаагүй задгайлахыг цээрлэнэ.

- Булаг шанд^⑧, нуур цөөрөм^⑨, ер нь усанд хог хийх бохирдуулахыг цээрлэнэ.

- Хамаа бусаар газар ухах, мод огтлохыг хориглон цээрлэж, үүнийг зөрчвөл газрын судас тасарч байгаль үхнэ гэдэг.

- Тогтмол усанд бие, хувцас хунарыг угаахыг цээрлэдэг.

- Онцгой ганц модыг огтлох, өөрцөг^⑩ хад хясааг^⑪ нураахыг цээрлэж харин ч шүтэж биширдэг.

- Газарт гадас, шон хатгаж орхих нүүгээд бууриа цэвэрлэхгүй байхыг цээрлэдэг.

- Хавар, мод, бут ногоорч цэцэглэж байх үед мод огтлох, хэзээ ч өсвөр зулзган мод^⑫ огтлохыг ямагт хориглодог.

- Цэцэг ногоо, үр жимсний бут, иш үндсийг зулгаахыг цээрлэдэг. Байгаль хамгаалах талаар Богд Чингис хааны “Их засаг”^⑬ хуулинд олон чухал заалт байсан тухай түүхч судлаачдын бичиж тэмдэглэсэн нь бий.

6. Хүмүүсийн харилцаатай холбогдсон цээрлэх ёсон

- Монголчууд уурлах тэрсэлдэхийг^⑭ нийтээр таашаадаггүй.^⑮

① 先进的，前面的；最好的，高级的；先锋，冠军，头头，首位；额，前额。

② 发情期（指骆驼等动物）。

③ 流动的，跑动的。

④ 氏族，部落。

⑤ 用烟灰涂抹，涂黑灰；抹黑，败坏名誉。

⑥ 吝啬，吝惜。

⑦ 碰，触动，刺激，激怒；挑起，挑衅，挑动；接触，触及，涉及。

⑧ 泉，小泉。

⑨ 池塘，水池，小湖。

⑩ 独特的，与众不同的。

⑪ 河崖，陡崖。

⑫ 幼树。

⑬ 《札撒》，亦称《大札撒》，原意为法度。成吉思汗制定，其主要内容包括公法、刑法、私法等。现已失传。

⑭ 反抗，反对，抗拒。

Ялангуяа баяр ёслол, зовлон гамшгийн үед уурлах уцаарлахыг машид цээрлэдэг.

- Хүнтэй эвгүй харьцах, эд юмс сэтгэл санаагаар хохироохыг цээрлэдэг.

- Амин хувиа хичээн ядарч зовсон хүнд туслахгүй өнгөрөхийг цээрлэдэг.

- Албаны буюу ахмад хүнтэй харилцахдаа ташаа тулах^②, эн зэрэгцэн суух, угзарган^③ том дуугарахыг цээрлэн, зүүн гарынхаа алган дээр баруун гараа хөмөрч алга хавсраад^④ хичээнгүйлэн байж үгий нь сонсдог ёстой билээ. Энэ бол сайхан ёс.

- Монголчууд хүнд хамаагүй гар хүрэх, ширүүн харахыг ч цээрлэдэг.

- Эмэгтэй хүн, эр хүний дэргэд үсээ самнахыг цээрлэдэг.

- Эр хүн, эмэгтэй хүний дэргэд бэлэггүй үг хараал, хатуу үг хэлэхийг цээрлэдэг.

- Эр нөхөр нь байхгүй үед айлд ирсэн хүн, гэрийн эзэгтэйн зөвшөөрөлгүйгээр малгайгаа авч тавих, бүсээ тайлахыг цээрлэнэ.

- Монгол хүн чанга хашгичих ярихыг цээрлэн “муу хүний дуу их, мухар хутганы мөр их” хэмээн шүүмжлэн ярилцдаг.

- Монгол хүн явган суух, хөлөө ачиж суухыг цээрлэж, тийм суугаа хүнтэй ярилцах дургүй байдаг.

- Арван найман нас хүрээгүй хүн айлд ороод тоононы голоос өнгөрч суудаггүйгээс гадна эмэгтэй хүн айлын хоймор голлож суудаггүй.

- Нүүж бууж байгаа айл, хашаа барьж, хадлан^⑤ авч байгаа, мал ноослож^⑥, эсгий хийж байгаа хүмүүстэй тааралдсан хүн туслахгүйгээр хэнэггүй өнгөрөхийг цээрлэдэг.

- Эм хүн, эр хүнд бардамнахыг^⑦, эр хүн эм хүнд бялахахыг^⑧ цээрлэдэг. Ингэвэл үйлс бүтэхгүй эрийн, эмийн тэнгэр хаядаг гэдэг.

- Монгол хүн, хүмүүс хоорондоо ярилцаж байхад дундуур нь орж

① таашаах 看得起, 欣赏, 看重, 赞赏, 赏识。

② 两手插腰。

③ 突然地, 猛地 (做出动作)。此处意为打断别人讲话, 插话。

④ 拼起手掌, 合掌。

⑤ 打草期, 割草期; 打草场; 割草, 打草; 打的草。

⑥ 取毛, 剪毛。

⑦ 骄矜, 傲慢, 自负, 狂妄; 吹嘘, 夸夸其谈。

⑧ 夸耀体力, 仗恃体力。

үгий нь таслах, ном үзэж байвал ном руу нь өнгийхийг цээрлэдэг.

7.Ахуй амьдралтай холбогдсон нийтлэг цээрлэх ёсон

- Монгол хүн эгц дээшээ харж толгойгоо салаавчлан хэвтэхийг өр алдсан^①, эсвэл сэтгэл санаа нь буруу болсон хүний шинж гэдэг тул толгой салаавчилж хэвтэхийг^② цээрлэдэг ёстой.

- Уруугаа харж сунаж хэвтэх нь хагацал^③ үзсэний шинж, үзэхийн ёр гэж цээрлэдэг.

- Шанаагаа тулж суух нь шаналсан буюу өвдсөн хүний шинж гэж үздэг тул шанаа^④ тулахыг цээрлэдэг.

- Монголчууд “Хэдий жаргалтай ч орондоо бүү дуул, хичнээн зовлонтой ч орондоо битгий уйл”хэмээн цээрлэдэг нь орондоо дуулаваас жаргал тогтодоггүй, орондоо уйлаваас зовлон тасардаггүй гэж үздэгийнх юм.

- Ор хоосон хонуулахыг цээрлэн эзгүй орхивол орон дээрээ сүх нүдүүр^⑤ зэргийг тавьдаг нь халуун ам бүлээ бүрэн бүтэн байлгах гэсэн бэлэгдэл юм.

- Үүд алдлах^⑥, босгон дээр гишгэх, суухыг цээрлэдэг нь муу ёр гэж үздэгийнх юм.

- Багана түших, зуурахыг^⑦ цээрлэдэг нь гай зовлон дуудсан муу ёр гэж үздэгийнх юм.

- Учир шалтгаангүй гэгэлзэн^⑧ дуулах, гэрт исгэрэх^⑨ нь сэтгэлд хий орохын шинж хэмээн цээрлэдэг.

- Нийтийн найр хуриман дээр “Шалзат^⑩ багахан шарга^⑪”, “Хулсан ташуур”зэрэг уй гашуудлын дуу дуулах аялахыг цээрлэдэг.

- Баганаар мал цохих, туух нь мал барагдах ёр даллана хэмээн цээрлэдэг.

- Гэртээ ховоо, өрхний оосор оруулахыг цээрлэнэ, оруулбал сүүнд

① өр алдах 意为苦闷, 忧愁, 苦恼, 苦痛, 惆怅, 郁闷。

② 双手交叉于脑后, 头枕着双手躺着。

③ 离别, 分离, 分开。

④ 颊; 颧。

⑤ 杵。

⑥ 用两臂平伸丈量, 用度量; 伸开双臂。

⑦ 紧抓, 紧夹, 紧咬。

⑧ 频频点头, 头一点一点。

⑨ 吹口哨。

⑩ 长有牛虱的, 长有壁虱的; 有红斑点的(马)。

⑪ 淡黄色的, 亮鬃草黄色的(指马的毛色)。

дүрж^① гаргана.

- Мал хөнгөлж зассаны^② дараа 3-7 хоног газар ухах хөндөхийг цээрлэдэг нь газар ус догширч малын засаа баалж^③ хүндрэхээс болгоомжилсон ёс юм.

- Морио хараах зүхэх, толгой руу нь цохихыг хатуу цээрлэдэг нь монгол хүн морио эрдэний хөлөг гэж хүндэтгэдгийнх юм.

- Жирэмсэн^④ хүн хутга, хайч, сүх зэрэг иртэй мэсийн зүйл дээгүүр алхдаггүй нь хэвлий^⑤ дэх хүүхдээ мэснээс айна хэмээн хайрласан сайхан ёсон юм.

- Өрхөө заавал татаж, хошуулдаж^⑥, оосрыг нь урд нь уяна, Нээлттэй хонохыг цээрлэнэ.

- Малын тамгаар газар тамгалахыг цээрлэдэг нь малаа барна гэснийх.

- Хадгийг угаах, тайрах^⑦, гишгэхийг цээрлэдэг нь хүндэтгэлийн ёсон.

- Хүүхдээ сарны гэрэл тусах газар унтуулахыг цээрлэдэг нь харь гаригийнхан хараад нялх хүүхдийг гэнэдүүлэн^⑧ дуудна гэж үздэгийнх юм. Энэ бол эртнээс баримталсан ёсон.

- Жирийн хүн ахмад хүний, эм хүн эр хүний урдуур гардаггүй нь хүндэтгэлийн ёсон юм.

- Галын хайчийг тэнгэр өөд, умар зүг рүү, ирсэн зочин руу чиглүүлэхийг цээрлэдэг нь хөөтэй^⑨ учраас юм.

- Ном, бичгийн хэрэглэл дээгүүр алхах, гишгэхийг цээрлэдэг нь ном бол оюуны түлхүүр хэмээн дээдэлдэгийнх юм.

- Монголчууд хутгыг хүнд бэлгэнд өгдөггүйгээс гадна, хаана ч ямар ч тохиолдолд хүн рүү хутганы үзүүр чиглүүлэхийг цээрлэдэг ёстой.

- Малын шагайг^⑩ таван хошуу малаараа бэлэгдэн хүндэтгэдэг учраас шагайг хог руу хаях, нутаг дээр орхихыг цээрлэдэг.

① 浸, 沾, 蘸; (用尖东西) 插入, 刺入, 扎入。

② 骗, 去势, 阉割。

③ 化脓, 肿胀。

④ 怀孕的, 妊娠的。

⑤ 腹部。

⑥ 折成三角, 对角线折叠; 削尖, 做出角。

⑦ 切下, 截去, 裁去。

⑧ 乘其不备, 出其不意; 诬诱, 诱骗。

⑨ 有烟灰的, 有锅灰的; 不愉快的, 麻烦的, 讨厌的。

⑩ 踝骨; 骰子。

- Монголчууд аливаа муу үйлийг илэрхийлсэн үгийг тэр үгээр нь хэлэхийг цээрлэн өөр үгээр орлуулан хэлдэг ёстой. Тухайлбал: үхэхийг “өөд болох”, мал алахыг “шөл гаргах”, “муулах”, чоно идсэнийг “боохой”^① зооглох”гэхчилэн ярьдаг.

- Гал голомт руугаа хутгаар чичих, тогооноос хутгаар мах гаргахыг цээрлэдэг.

- Монгол айл аргалын дөрвөлж, түлээний авдраа “галын сан” гэж үздэг тул дундуурхан байх, дээр нь сандайлж^② суухыг цээрлэж ямагт түлшээр дүүрэн байлгахыг хичээдэг.

- Монголчууд нас барсан хүний нэрийг хэлэхийг цээрлэж “Өөд болооч”, “Бурхан болооч”, “Талийгаач” гэдэг. Талийгаачийг онь хөтөл^③, өөрцөг хад, ганц модны дэргэд оршуулахыг цээрлэдэг.

- Талийгаачийг оршуулснаас хойш 7 хоногийн дотор нүүхийг 21 хоногийн дотор золгох, айлд юм өгөхийг, 49 хоногийн дотор мод огтолж, газар хөндөх, мал гаргахыг цээрлэдэг. Энэ нь монголчууд эртнээс хүмүүст сүнс^④ байдаг. Тэгээд талийгаачийн сүнс 49 хоногийн дотор орон гэр ах дүүс, үр хүүхдээсээ холдолгүй эргэж тойрч байдаг гэж үздэгийнх юм.

Уншигч авхай^⑤ таны ухаан цэлмэж, гэр хотлоороо дүүрэн баяртай, төвшин жаргалтай явах болтугай. (1881 үгс)

作业:

1. 指出本文所述与汉民族习俗截然不同的蒙古习俗。
2. 谈谈蒙汉两个民族习俗的特点。

① 狼（委婉语）。

② 垂足而坐，悬腿而坐。

③ 狭溪；鞍状山脊；马脊置鞍处；两峰间之凹处。

④ 灵魂；精神。

⑤ 小姐，女士；先生，君（尊称）。

2-р хичээл МОНГОЛ БИЧИГ ҮСГИЙН ТУХАЙ

Монголчууд бичиг үсгийн мянгаад жилийн түүхтэй юм. Манай өвөг дээдэс анх нүүдэлчин аймгийн бүдүүдэг нөхцөлд тохирсон дээсэн бичиг^① (Дээсийг янз бүрээр зангидан^② элдэв үзүүр гогцоо^③ гаргаж түүгээрээ дохио болгож харилцаж байжээ) хэрэглэж байжээ. Түүний дараагаар модон бичиг^④ (3-4 цунгийн^⑤ хэмжээтэй хавтгайлан^⑥ зассан модон дээр элдэв дүрсийг сийлбэрлэн^⑦ зурж, утга санаагаа ойлголцож байв) хэрэглэх болсон нь бичиг үсгийн үлэмж боловсронгуй шинэ дэвшилт юм. Монголчуудын мэдлэг ухаан хөгжихийн хирээр модон бичиг нь улам боловсронгуй болж, ерийн бүдүүлэг дүрс тэмдгээс үлэмж нарийн хэвшсэн авиа тэмдэглэх үсэг болтлоо хөгжжээ. Ер монгол газар оршин сууж байсан эртний аймаг улсууд цөм бичиг үсэгтэй байжээ. Эртний Хүннүчүүд хятадын дүрс үсгийг^⑧ хэрэглэж байсан бөгөөд бас зарлиг тушаалд дарах тамга^⑨ тэмдэг, газрын зураг зэргийг зохион хэрэглэж байсан сонин мэдээ бий. Мөн эртний Сяньби^⑩ улсын үед (м.э.ө.1-111 зуун) бичиг үсэг хэрэглэж байсан бөгөөд хожим Жужанчууд^⑪ хятад үсгийг хэрэглэж байжээ. Монголын эртний соёлт аймгийн нэг болох Кииданчууд бүр VII зууны үеэс авианы бичиг^⑫ хэрэглэж байжээ.

Кидан гүрнийг үндэслэн байгуулсан Амбагянь^⑬ ач хүү Лубугу,^⑭ эрдэмтэн Туйлюбу^⑮ нар хятад дүрс бичигт тулгуурлан Киданы “их

① Дээсэн бичиг 结绳(古代一种记事方法)

② зангидах 打结儿, 结疙瘩.

③ Гогцоо 绳扣; 套索; 环扣, 小钩.

④ Модон бичиг 讯木(古代一种记事方法)

⑤ цун 寸(中国计量单位)

⑥ хавтгайлах 弄平.

⑦ Сийлбэрлэх 雕刻.

⑧ Дүрс үсэг 象形文字.

⑨ Тамга 印章, 图章.

⑩ Сяньби 鲜卑, 古族名.

⑪ Жужан 柔然, 古族名.

⑫ Авианы бичиг 拼音文字.

⑬ Амбагянь (Елюй Амбагянь) 耶律阿保机, 辽太祖.

⑭ Елюй Лубугу 耶律鲁不古, 字信宁, 辽太祖从侄.

⑮ Елюй Туйлюбу 耶律突吕不, 契丹大字创制者之一.

бичиг"-ийг^① 920 онд зохиожээ. Энэ бичиг нь Алтан улс^② даяар ихэд дэлгэрсэн бөгөөд түүний дурсгалууд Киданы хаадын булш, Чин толгойн балгас, Хэнтийн салбар уулс орчмоор олдсон билээ. Мөн Киданы хаан Амбагяны хүү Елой Тэла^③ уйгуржин бичигт^④ тулгуурлан Киданы "бага бичиг"-ийг^⑤ зохиосон бөгөөд түүний зарим дурсгалд эдүгээ Архангай аймгийн Бугат сумын хаалгатын амнаас олджээ. Ер Монголын дорно талын аймгууд нь хятад бичгийг эртнээс хэрэглэж, улмаар XIII-XIV зууны үе болж ирэхэд хятад үсгээр монгол үгийг бичиж тэмдэглэх аргыг нэгэнт нарийн нягт боловсруулсан байв. Хятад үсгээр бичсэн "Монголын нууц товчоо", "Хуа-и-и-юу"^⑥ гэдэг толь бичиг, Монгол, Хятадын хаадын харилцан илгээсэн 12 захидал бичиг зэрэг дурсгалууд үлджээ. Мөн энэ үеэр монголын өрнө талын Хэрэйд,^⑦ Найман^⑧ зэрэг соёлт аймгууд Согдоос^⑨ гаралтай уйгур бичгийг хэрэглэж байжээ. Анх монголчууд уйгур бичгийг нэмж засварлалгүй хэвээр хэрэглэж байсан бөгөөд яваандаа^⑩ түүнийг эх хэлэндээ зохицуулан засах гэсэн оролдлогууд удаа дараалан гарч зохих амжилтанд хүрчээ. XIII зууны эхээр Чингис хаан баруун зүгийн соёлт монгол аймгуудыг дайлаар эзэлж^⑪, улмаар тэдгээр аймгийн хэрэглэж байсан уйгур бичиг нь нийт монгол аймгуудын дунд дэлгэрчээ. Энэ нь улмаар уйгур бичгийг олон монгол хэл аялгууны^⑫ үгийг адил тэгш хэрэглэж чадахуйц болтол дахин нарийвчлан боловсруулахад хүргэсэн байна.

Уйгуржин бичгийг нийт монгол хэл аялгуутанд зохицуулдан засах оролдлого тэр үедээ олон гарсан нь маргаангүй бөгөөд тэдгээрийн дотроос түүхэнд тэмдэглэсэн нь төвдийн эрдэмтэн Саж

① Киданы их бичиг 契丹大字.

② Алтан улс 金朝.

③ Елой Тэла 耶律迭剌, 辽太祖弟.

④ Уйгуржин бичиг 回鹘文.

⑤ Киданы бага бичиг 契丹小字.

⑥ Хуа-и-и-юу 《华夷译语》, 明太祖朱元璋时, 任翰林院侍讲的蒙古族学者火原洁等主编纂辑的蒙汉文对照词汇集.

⑦ Хэрэйд 克烈亦惕, 部族名.

⑧ Найман 乃蛮, 部族名.

⑨ Согд 粟特, 中亚西亚古国.

⑩ Яваандаа 自然而然地, 在……过程中.

⑪ Дайлаар эзлэх 攻占.

⑫ Аялгуу 方言; 口音.

бандида Гунгаажалцан (1188-1251)-гийн^① бүтээл юм. Тэрээр Годан^② хааны үед (1237) монгол газар уригдан ирээд долоон жилийн турш монгол хэл аялгуунуудыг судлан, улмаар уйгуржин бичгийг түүнд тохируулан нэмж засаад, зохих дүрэм зүйг боловсруулжээ. Гунгаажалцан зөвхөн дүрэм зүй зохиоснаар барахгүй, хэл шинжлэлийн нарийн үндэстэй том бүтээл туурвижээ^③. Тэр нь монгол хэл шинжлэлийн түүхэнд “Анхдугаар зүрхний толь” хэмээн алдаршсан билээ. Сажа бандидагийн нэмэн зохиосон бичиг нь өмнөх үеийнхээ уйгур бичгээс үлэмж дэвшилттэй боловч монгол бичгийн хэлний үүргийг бүрэн дүүрэн гүйцэтгэж хараахан чадаагүй билээ.

Тэр цагт монголын их гүрний дотор багтаж байсан бүх улс аймаг хийгээд соёлын хамааны бусад улс дундын боловсронгуй бичигтэй болох гэсэн сонирхол Хубилай^④ хааны ордныхонд хүчтэй байжээ. Ийм бичгийг зохиох үүрэг Хубилай хааны зарлигаар төвдийн эрдэмтэн Пагба лам Лодойжалцанд^⑤ оногджээ. Тэрээр төвд үсэгт тулгуурлан бүгд 50 толгой үсэг бүхий дөрвөлжин үсгийг^⑥ зохиож, улмаар түүнийг 5-р равжунгийн^⑦ шарагчин могой жил^⑧ (1269) төрийн бичиг болгон тунхагласан байна. Энэхүү дөрвөлжин бичиг нь олон улс үндэстний хэл аялгууг тэгш тэмдэглэж чадах сайн талтай боловч монголын олон аялгуунуудын нийт дундын байдлыг бүрэн хадгалж чадаагүй тул олон даяар төдий л удаан хэрэглэсэнгүй. Хэдий тийм боловч XIII-XIV зууны үеэр дөрвөлжин бичгээр бичигдсэн хөшөө дурсгал, пайз^⑨ бичиг, нилээд ном зохиол гарсан бөгөөд эдүгээ тэдгээрийн зарим нь уламжлан үлдсэн билээ. XIII зууны сүүлч, XIV зууны эхээр монгол газар Энэтхэгийн Буддийн шашин дэлгэрч, улмаар Буддийн шашны сургаал номлол, хийгээд гүн ухаан^⑩ анагаах ухаан, учир шалтгааны ухааны^⑪ өдий төдий

① Сажа бандида Гунгаажалцан 萨迦班智达·贡噶坚赞，藏传佛教萨迦派教主。

② Годан 阔端，成吉思汗孙，太宗窝阔台子。

③ Туурвих 撰写，著述，写作。

④ Хубилай 忽必烈，元世祖。

⑤ Пагба лам Лодойжалцанд 八思巴，西藏萨迦派佛教的五世祖，原名罗岱坚赞（1238-1280），为元世祖尊为国师。

⑥ Дөрвөлжин үсэг 方块字，即八思巴文。

⑦ Равжун 饶迥，藏历运用时轮纪年法把六十年一个循环称为一个“饶迥”。

⑧ Шарагчин могой жил 土蛇年（藏历）；己巳年。

⑨ Пайз 牌子。

⑩ Гүн ухаан 哲学。